



МОНГОЛ УЛС  
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,  
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2018.12.06 № 05/10265.  
танай 2018.11.20 № 08/5587

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан  
мэдүүлгийг хянасан тухай

Зам, тээврийн хөгжлийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийн газрын Төмөр замын тээвэр зохион байгуулалт хариуцсан ахлах мэргэжилтнээр томилогдохоор нэр дэвшсэн Мөнхнасангийн Гомбожав, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын Төмөр замын тээврийн ачаа тээвэр, галт тэрэгний хөдөлгөөн зохион байгуулалтын хяналт хариуцсан мэргэжилтнээр томилогдохоор нэр дэвшсэн Мөнхтэгшийн Онон, тус газрын Гүүр, инженерийн хиймэл байгууламжийн хяналт хариуцсан мэргэжилтнээр томилогдохоор нэр дэвшсэн Бадрахын Насантогтох нарын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянан үзэхэд тухайн албан тушаалд томилоход ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Төмөр замын тээврийн зохион байгуулалт хариуцсан ахлах мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтын ерөнхий шаардлагын мэргэжил хэсэгт Төмөр замын тээврийн удирдлага, зохицуулалтын инженер, мэргэшил хэсэгт Төмөр замын мэргэшсэн инженер, туршлага хэсэгт Мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан байх гэснийг нэр дэвшигч М.Гомбожав нь хангаагүй байгааг анхаарна уу.

Нэр дэвшигчид нь тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөл байдалд дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж байх, мөн хуульд зүйлд заасан хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй.

Түүнчлэн нэр дэвшигч нар нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3, Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т заасан хугацаанд хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргахыг анхаарна уу.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН  
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА  
ЭРХЭЛСЭН КОМИССАР



Х.ХАШБААТАР

0016941